

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

ЦЭЭСҮРЭНГИЙН ТУНГАЛАГТАМИР

**УЛААНБААТАР ХОТЫН ЦУСНЫ ДОНОРУУДЫН БҮТЦИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД , ТЭДГЭЭРИЙГ БҮСИЙН ЗАРИМ ОРНЫХТОЙ
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Е 720001 Нийгмийн эрүүл мэнд

Нийгмийн эрүүл мэндийн магистрийн зэрэг
ГОРИЛСОН БҮТЭЭЛИЙН ХУРААНГУЙ

Улаанбаатар хот
2007 он

ЭМЯ-ны харъяа Цусны төв (захирал Д. Улаанхүү)-д хийж гүйцэтгэв.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Н. Сүмбэрзул, АУ-ны доктор, Дэд профессор

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

Д. Улаанхүү, Клиникийн профессор

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Х. Дамдинжав, Философийн ухааны доктор (PhD), Дэд профессор

Магистрийн хамгаалалт 2007 оны ... сарынөдрийн,цагт 202
тоот өрөөнд болно.

Био-Анагаах, НЭМ-ийн салбар эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн
дарга,

..... АУ-ны доктор (PhD), О.Чимэдсүрэн.

УДИРТГАЛ

1.1. Судалгааны ажлын үндэслэл

Аливаа улс орны цусны албаны үйл ажиллагаа нь жинхэнэ өгөөмөр, бодь сэтгэлийн үүднээс, сайн дураараа, авлагагүйгээр цусаа бэлэглэгч доноруудад тулгуурлаж байдаг билээ.

ДЭМБ-ийн тооцоолсноор хүн амынх нь 3-5% нь цусаа өгч байж тухайн орон өөрийн орны цус, цусан бүтээгдхүүний хэрэгцээгээ бүрэн хангадаг байна гэж үздэг.

Хүн амын эрсдэл багатай бүлгээс сонгосон сайн дурын авлагагүй доноруудаас цус цуглуулах, эрүүл зан үйл эрхэмлэхийн чухлыг сурталчилахыг ДЭМБ-ын “Цусны аюулгүй хангамжийг сайжруулах талаар баримталж байгаа стратеги 2”-т заасан.

Өдөр тутмын эмнэлгүүдийн хэрэгцээний болон зайлшгүй шаардлагатай үеийн цус цусан бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, байгалийн болоод хүний үйл ажиллагаатай холбоотой болзошгүй гамшгийн үед / терроризм гэх мэт / шаардагдаж болзошгүй цусны болон донорын нөөцийг бүрдүүлэх шаардлагатай байгаа юм. Улаанбаатар хотод шилжин суурьшиж байгаа хүн амын тоо нэмэгдэн бэртэл, гэмтэл, хорт хавдарын өвчлөл нас баралт ихсэж байгаагаас Улаанбаатар хотын төрөх, бусад эмнэлгүүдийн хэрэглэж байгаа цус цусан бүтээгдэхүүний хэмжээ эрс нэмэгдэж байна. Цусны төв жилдээ 3800 литр цус цуглуулж байгаа боловч эмнэлгийн байгууллагуудын шаардлагатай хэрэгцээний зөвхөн 60%-ийг хангаж байна.

ДЭМБ-аас Цусны аюулгүй хангамжийг сайжруулах талаар баримталж байгаа стратеги зорилтуудыг хэрэгжүүлж, трансфузиологийн шинжлэх ухааны орчин үеийн хөгжлийн түвшинд ойртон очихын тулд аюулгүй, найдвартай, жигд хүртээмжтэй цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааны үндэс болсон цусны донорын өнөөгийн байдлыг судлан тогтоох нь зайлшгүй шаардлагатай байгаа юм.

1.2. Судалгааны ажлын зорилго

Улаанбаатар хотын цусны донорын үзүүлэлтийг судлан тогтоож бүсийн бусад орнуудынхтай харьцуулан судлахад судалгааны зорилго оршино.

1.3. Судалгааны ажлын зорилтууд

1. Цусны төвийн донорын үзүүлэлт, түүний өөрчлөлтийг тодорхойлох
2. Доноруудын өгсөн цусны хэмжээ, шинжилгээгээр хасагдалтыг цус цуглуулсан хэлбэр, нас, хүйс, ажил эрхлэлтийн байдалтай холбон судлах
3. Бүсийн зарим орны донорын үзүүлэлттэй харьцуулан судлах

1.4. Хамгаалахаар дэвшүүлж буй асуудал

Цусны төвд цусаа өгсөн донорын бүтэц, бүрэлдхүүний өөрчлөлт, тэдгээрийн хоорондын хамаарал (өгсөн цусны хэмжээ, шинжилгээгээр хасагдалт, цус цуглуулсан хэлбэр, нас, хүйс, ажил эрхлэлтийн байдал)

1.5. Судалгааны ажлын шинэлэг тал

Цусны донорын бүтцийн үзүүлэлтүүдийг харьцуулан судалж дүгнэлт өгсөн анхны судалгаа болно.

1.6 Судалгааны ажлын практик ач холбогдол

Донор сонголтын ажлын чиглэл, бодлого боловсруулах, донорын сургалт, сурталчилгааг зохион байгуулахад шийдвэр гаргагч нарыг нотолгоонд суурилсан мэдээлэлээр хангаж буйд уг ажлын практик ач холбогдол оршино.

1.7. Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. “Улаанбаатар хотын цусны доноруудын бүтцийн үзүүлэлтүүд, тэдгээрийг бүсийн зарим орныхтой харьцуулсан судалгаа” ЭМШУИС, НЭМС, Урьдчилан сэргийлэх анагаах ухааны тэнхимийн хурал /2006 оны 11 дүгээр сар/
2. “Донорын хөдөлгөөнд залуучуудын оролцоо” сэдвээр ОУУЗУХСНХ-ны 10 коллокумд илтгэл. Бээжин хот. 2002 он
3. 2006 оны Монгол улсын цусны албаны эрдэм шинжилгээний 4-р бага хуралд “2005 онд цус, сийвэнгээ өгсөн доноруудын бүтцийн судалгаа” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлсэн.